

**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ГУРВАН САЙХАН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН
/ТОВЧЛОЛ/**

2019.10.30

Даланзадгад сум
6 дугаар баг

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Дотоод аудитын зорилго, үндэслэл

ИНЕГ-ын даргын баталсан 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Өмнөговь аймаг дахь Гурван сайхан нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 19/26 тоот удирдамжийн хүрээнд 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа, Ц.Цацрал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Өмнөговь аймаг дахь Гурван сайхан нисэх буудлын 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, нисэх буудлын даргын гаргасан тушаал шийдвэрийн эрх зүйн үндэслэл, хүний нөөц бүрдүүлэлт, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлт, худалдан авалт, цалин хөлсний бодолт, олголт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Өмнөговь аймаг дахь Гурван сайхан нисэх буудлын 2018 оны санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд аудитын шалгалтыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газраас түүвэр аудитаар хийсэн ба аудитаар материаллаг хэмжээний зөрчил илэрээгүй байна.

Ажилтнуудын хөдөлмөрийн гэрээний нөхцөл буруу бичигдсэн, цалингийн сүлжил бичээгүй, хөдөлмөрийн гэрээний хугацааг буруу бичсэн, мөн ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлээгүй байна.

Нисэх буудлын барилгын суурьд суулт үүсч, өрөөний хаалга, цонхнуудын хүрээ гажсан, дээврээс дусаал гоождог, салхи сийгэж дулаан алдалт ихтэй, суулт үүсч гажсанаас элс, шороо чигжиж тоног төхөөрөмж гэмтээх, цахилгааны утсууд сендвичэн дээврийн холбоос төмөр дээгүүр дамждагаас богино холболт үүсэх зэрэг аюултай нөхцөл байдалтай болсон байна. Мөн бохирын цооног, уурын зуух нь салхины дээд талд байрлалтайгаас зуны цагт зорчигч, үйлчлүүлэгч нарт бохир үнэртэж, таагүй сэтгэгдэл төрүүлдэг, өвлийн цагт перрон руу уурын зууны яндангаас оч үсэрч орох зэрэг аюул байна.

Нислэгийн өмнөх, дараах шүүмж яриаг тогтмол хийж тухайн өдрийн нислэгийн үйл ажиллагаанд гарсан алдаа, зөрчил, дутагдлыг хэлэлцэж, гарсан алдаа зөрчлийг тухай бүр залруулж ажиллажээ.

2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө нь үндсэн асуудлын гарчигийг тавиагүй, дугаарлалт буруу, дугааргүй, үг үсэг, утга найруулгын алдаатай байна.

Тус нисэх буудалд ажил олгогчийн мэдлийн өмч хөрөнгийг бүртгэн авч, бүрэн бүтэн байдлыг хангах, хадгалах, хамгаалах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бусдад



шилжүүлэх үүрэг хүлээсэн эд хариуцагчийг албажуулаагүй, албан тушаалын тодорхойлолтод зааж өгөөгүйгээс эд хөрөнгө хадгалалт хамгаалалт хангалтгүй, бараа материалууд агуулах, гарааж зэрэгт тархан байршсан, хөрөнгө үрэгдэх, чанар муудах зэрэг эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн байна. Ингэснээр Сангийн сайдын 2000 оны 69 дүгээр тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-д заасан чиг үүрэг биелэгдэхгүй байна.

Нисэх буудлын даргын тушаалууд нь баримт бичгүүд болон хэвлэмэл хуудсанд тавигдах нэгдмэл шаардлагыг тогтоож, улмаар улсын хэмжээнд нэг мөр журамлан явуулах зорилгоор гаргасан эрх зүй-техникийн шинжтэй гаргасан баримт бичгийн стандартын дагуу хийгдээгүй, үг үсэг, утга найруулгын алдаа ихтэй байна. Мөн тушаалын бүртгэлийг дутуу хөтөлсөн, үндсэн үйл ажиллагаатай холбоотой А болон боловсон хүчинтэй холбоотой Б тушаалуудын бүртгэлийг нэг бүртгэлээр хөтөлсөн байна.

Нүүрс, тээврийн зардлыг нүүрсний өртөгт шингээж орлого авахаар ИНЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/901 дүгээр тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийн “4.3. Бараа материалын бүртгэл”-ийн 86 дугаар хуудсанд ...Бараа материалын өртөгт худалдан авалтын өртөг, хувиргалтын өртөг, одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг авчрахтай холбогдож гарсан бүх зардал орно... гэж заасныг зөрчсөн байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоогоор цалин хөлс илүү, дутуу олгосон зөрчил гарсан.

Хоолны үнийн хөнгөлөлтийн тооцоогоор илүү олгосон зөрчил гарсан.

Гадны иргэн, байгууллагуудтай хийсэн гэрээнд гэрээний дугаар тавиагүй, гэрээний зүйл тодорхойгүй, гэрээний үнийн дүн тавигдаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй зэрэг зөрчил дутагдал илэрлээ.

Шатахууны худалдан авалт нь нийт дүнгээрээ нээлттэй тендер шалгаруулалтын журам мөрдөж ажиллах байтал шууд худалдан авалт хийсэн байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д заасан ...Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна..., 7.1.1-д заасан ...нээлттэй тендер шалгаруулалтын журам... гэж заасныг мөрдөж ажиллаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

Нүүрс, мод тээврийн гэрээ нь дугааргүй, дуусах хугацаа тодорхойгүй байгаагаас гадна шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2.-т заасан ...шууд худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар... гэсэн заалтыг зөрчсөн байна. Худалдан авах ажиллагаанд мөрдөх харьцуулалтын аргыг ашиглах журмыг мөрдөж ажиллаагүй байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хангаж ажиллахад анхаарч, хуулийн хугацаанд

Авто тээврийн хэрэгслийн хувийн хэргийг тухайн хэсгийн хариуцсан ажилтан дутуу хөтөлдөг, дотоод хяналт хийдэггүй зэрэг дутагдал илэрсэн байна.

Худалдан авах болон ажил үйлчилгээ үзүүлэхдээ хуулийн дагуу зохион байгуулах, гэрээг хуулийн хүрээнд боловсруулах, гэрээг дүгнэж акт бүрдүүлж байх шаардлагатай байна.



Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар тус нисэх буудалд 11 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА